



**ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮҮН Г.ЦОГТГЭРЭЛИЙН 2023 ОНЫ 2 ДУГААР
УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 07-р сарын 17

Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Г.Цогтгэрэл миний бие 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохиетой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг тус тус хэрэгжүүлэн ажилласан болно.

1. ТУЗ-ийн хуралд оролцсон байдал:

2023 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 2 хурал зарлагдсанаас хараат бус гишүүний хувьд бүх хуралд 100% ирцтэйгээр асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон байна. Үүнд:

1. Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд хавсралт ёсоор нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн батлахаар шийдвэрлэв.
2. Банкны ТУЗ-ийн дэргэдэх эрдэлийн удирдлагын хорооны журмыг шинэчлэн хавсралтаар батлахаар шийдвэрлэв.
3. Банкны 2022 оны Хөндлөнгийн Аудитын тайлантай танилцаж хэлбөгдох журмын дагуу тус тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар буюу 2023 оны 04 дүгээр сарын 28-ны хурлаар хэлэлцүүлж батлуулахаар шийдвэрлэв.

4. Ногдол ашиг хуваарилах эсэх талаарх асуудлыг хэлэлцэн банк нь 2023 онд ногдол ашиг хуваарилахгүйгээр санал гаргаж тус асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар шийдвэрлэв.
5. Тээвэр хөгжлийн банкны Тогтворжуулах төлөвлөгөөг хавсралт ёсоор батлав.
6. Банкны Гүйцэтгэх удирдлагын багийн ажлын тайлантай танилцав.
7. Банкны 2022 оны Үйл ажиллагааны тайлантай танилцаж тус тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар шийдвэрлэв.
8. Тээвэр хөгжлийн банкны Ёс зүйн дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн батлав.
9. Тээвэр хөгжлийн банкны Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хавсралт ёсоор шинэчлэн батлав.
10. БНХАУ-д Тээвэр хөгжлийн банкны Хятад улс дахь Төлөөлөгчийн газар байгуулахыг зөвшөөрч, төлөөлөгчийн газар байгуулахтай холбоотой холбогдон гарах зардал, төсвийг хавсралтаар батлав.
11. Тээвэр хөгжлийн банкны Тогтворжуулах төлөвлөгөөнд хавсралт ёсоор нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн батлав.

ТУЗ-ийн хурлаар дээрх асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхэд хараат бус гишүүний хувьд саналын зорүүртэй зүйл байгаагүй. Банкны Хувьцаа эзэмшигч, ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын нэг төл абыг шийдвэр гаргалт нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж журмын дагуу байсан бөгөөд ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоолууд нь банкны харилцагч, халгаламж эзэмшигчийн эрх ашгт сөргөөр нөлөөлөхөөргүй байсан болно.

2. Аудитын хороонд ажилласан тухай:

Аудитын хороо нь 2023 оны 2-р улиралд 1 удаа буюу 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

1. Дотоод аудитын газраас өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийн байдал
2. Дотоод аудитын газраас Хууль, эрх зүйн газарт хийсэн аудитын тайлангийн тухай

Аудитын хорооны хурлаас дараах санал дүгнэлтийг гаргасан болно. Үүнд:

1. Дотоод аудитын газраас Гүйцэтгэх удирдлагад өгч буй зөвлөмжийн биелэлтийн байдлыг цаашид тодорхой давтамжтай ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд танилцуулж байхыг үүрэг болгов.

2. Хуудь эрх зүйн газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашил зөрчлийг давтан гаргахгүй байх, өгсөн зөвлөмжийг заасан хугацаанд хэрэгжүүлж ажиллах талаар Хууль, эрх зүйн газрын захиралд анхааруулга, үүрэг өгөв.

3. Эрсдэлийн удирдлагын хороонд ажилласан тухай:

Эрсдэлийн удирдлагын хороо тайлант хугацаанд 1 удаа буюу 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

1. Эрсдэлийн удирдлагын хорооны журманд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
2. Банкны Тогтворжуулах төлөвлөгөөг хэлэлцэх тухай


Эрсдэлийн хорооны хурлаар дараах санал дүгнэлтийг гаргасан болно.

1. Эрсдэлийн удирдлагын хорооны журманд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэв.
2. Банкны Тогтворжуулах төлөвлөгөөг хэлэлцэж ТУЗ-ийн хурлаар батлуулахаар шийдвэрлэв.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд эрсдэлийн хорооны хурлаас гаргасан дүгнэлттэй саналын зөрүүтэй зүйл байгаагүй. Эрсдэлийн хорооны хурлаас гарсан санал, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.

Тайлан бичсэн:

ТУЗ-ийн хараат бус гишүүн

 Г.Цогтгэрэл